



БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2017/12

www.bulgan.nso.mn



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
аппликейшн

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Статистик
мэдээлэл

Вндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	14
I. 2 Хөдөлмөр.....	15
I. 3 Нийгмийн даатгал.....	16
I. 4 Эрүүл мэнд	17
I. 6 Гэмт хэрэг	17
II.3 Үнэ.....	19
II.7 Аж үйлдвэр.....	24
II.8 Барилга.....	25
II.9 Холбоо.....	25
II.13 Худалдан авах ажиллагаа.....	26
II.14 Хөдөө аж ахуй.....	26

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

2017 оны байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 1239 хүүхэд, нас барсан 370 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 36 буюу 2.8 хувиар, нас баралт 35 буюу 9.4 хувиар тус тус буурчээ.

Зураг I.1.2


Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



1140 хүн шилжин ирж, 1322 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 181 буюу 15.8 хувиар, шилжин явсан хүн 341 буюу 25.8 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.1.3

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгч иргэн 1008 болсны 491 нь эмэгтэй байна. Ажил хайгч иргэдийн 0.4 магистр, докторын, 17.1 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.8 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.4 хувийг техникийн болон мэргэжлийн, 59.3 хувийг бүрэн дунд боловсролтой, 7.1 хувийг суурь боловсролтой, 1.4 хувийг бага боловсролтой, 1.3 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1

Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 13.0 хувийг 15-24 насны, 34.2 хувийг 25-34 насны, 23.1 хувийг 35-44 насны, 21.7 хувийг 45-54 насны, 5.4 хувийг 55-59 насны, 2. хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр



I.3. Нийгмийн даатгал, халамж Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны жилийн эцсийн байдлаар 12665.5 сая төгрөг, зарлага 35444.9 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 667 сая төг буюу 5.6 хувиар өсч, зарлага 3962.2 сая төг буюу 12.6 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 667 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 211.5 сая.төг буюу 2.9 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 149 сая.төг буюу 18 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 299.9

сая.төг буюу 9.5 хувиар, өссөн нь голлон нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 3962.2 сая.төг буюу 12.6 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сан 2222 сая.төг буюу 8.1 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 1239.7 сая.төг 54.9 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 20.3 сая.төг буюу 5.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны жилийн эцсийн байдлаар 13921 хүн 4865.1 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 56.2 сая.төг буюу 1.2 хувиар өсч харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 1238 хүн хамрагдаж 1657.2 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 119.1 сая.төг буюу 6.7 хувиар буурсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 8424 хүн хамрагдсаны 19.9 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 20.4 хувь ахмад настан, 4.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 53.7 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 1544.5 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 98.6 сая.төг буюу 6.8 хувиар өссөн байна.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 825 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 835 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 43 буюу 5 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 46 буюу 4.8 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.4.1


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 4 жилийн байдлаар



Нялхасын эндэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеээс 1 буюу 15 хувиар буурсан байна.

Зураг I.4.2

Эндсэн хүүхэд, сүүлийн 4 жилийн байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2017 жилийн эцсийн байдлаар 352 болж, өмнөх оны мөн үеийнхээс 290 тохиолдол буюу 45 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 194 буюу 55.1 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 158 буюу 44.9 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сүүлийн 4 жилийн байдлаар



I.5. Байгаль орчин

2017 оны 1 дугаар сарын урьдчилсан мэдээ

Энэ сарын агаарын температурын дундаж нь томоохон голуудын хөндийгөөр 26-31 градус, нутгийн өмнөд хэсгээр 11-16 градус, бусад нутгаар 18-23 градус хүйтэн буюу нутгийн зүүн хэсгээр олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. (1 дүгээр зураг).



Энэ сард орох цасны хэмжээ нь нутгийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, нутгийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй. /2 дугаар зураг/.



Сарын эхээр хүйтний эрч бага зэрэг суларч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 29-34 градус, өдөртөө 17-22 градус хүйтэн, бусад

нутгаар шөнөдөө 21-26 градус, өдөртөө 11-16 градус хүйтэн байна. Харин сарын дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр хүйтний эрч чангарч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 41-46 градус, өдөртөө 25-30 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 31-36 градус, өдөртөө 21-26 градус хүйтэн байна. Бусад хугацаанд томоохон голын хөндийгөөр шөнөдөө 32-37 градус, өдөртөө 18-23 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 23-28 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна.

Нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, 18-23-нд ихэнх нутгаар, 25-дын үеэр нутгийн зүүн хэсгээр цас орно. Энэ үеэр салхи зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсч зөөлөн цасан шуурга шуурах төлөвтэй.




I.6 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 362 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 97 хэргээр буюу 36.6 хувиар өссөн байна.

Зураг I.6.1

Бүртгэгдсэн гэмт хэрэг




Хэргийн өнгөөр нь авч үзвэл

- ХЭМХБЭГХ /ИЭЧЭМЭГХ/ 101 бүртгэгдэж 9 хэргээр буюу 9.7 хувиар
- ХБОЭГХ /БХЖЭГХ/ 24 бүртгэгдэн 19 хэргээр буюу өмнөх оны мөн үеийнхээс 3.8 дахин
- Бусдын амь насыг болгоомжгүй алах гэмт хэрэг 3 бүртгэгдэж 2 дахин
- Хулгайлах гэмт хэрэг 114 бүртгэгдэж 13 хэргээр буюу 12.8 хувиар тус тус өссөн.
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг 3 бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 4 хэргээр буюу 57.1 хувиар
- Хүчингийн гэмт хэрэг 5 бүртгэгдэж 50 хувиар
- Мал хулгайлах хэрэг 35 бүртгэгдэж 4 хэргээр буюу 10.2 хувиар тус тус буурсан.
- ХАБЭГХ /ХАБАЖЭГХ/ 26 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол
Гэмт хэргийн улмаас нийт иргэд , аж ахуй нэгж байгууллагад 1346.4 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 1224 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 758.4 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан .

Зураг I.6.2

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/




Гэмт хэргийн улмаас 25 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.8 хувиар буурсан байна.

Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 7, болгоомжгүй хүний амь насыг хохироох гэмт хэргийн улмаас 3, бусдыг санаатай алах гэмт хэрэгийн улмаас 2, ХАБАЖЭГХ-ийн улмаас 13 иргэн тус тус амь насаа алдсан байна.

Гэмт хэргийн улмаас 153 иргэн гэмтсэн нь ИЭЧЭМЭГ хэргийн улмаас 63, ХАБАЖЭГ хэргийн улмаас 22, бусад хэргийн улмаас 79 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 21.4 хувиар өссөн байна.

Зураг I.6.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн




II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 2017 оны жилийн эцсийн байдлаар 54025.5 сая төгрөг, зарлага 53697.1 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 328.4 сая төгрөгний эерэг гарлаа.

Зураг II.1.1


Аймгийн төсвийн орлого, зарлага сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 37.9 хувийг татварын орлого, 4 хувийг татварын бус орлого, 58.1 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2017 оны жилийн эцсийн байдлаар 53697.1 сая.төг болоход 73.7 хувийг бараа ажил үйлчилгээний зардал, 16.5 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Нийт авлага 38.9 сая. өглөг 227.8 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин. НДШ-ийн өр 102.5 сая төг. халаалт. гэрэл цахилгаан. цэвэр бохир усны өр 69.6 сая. эмийн өр 36.5 сая. албан томилолт 6.6 сая. бусад зардлын өглөг 12.6 сая төгрөг байна.




II.3 Үнэ Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 2.4 хувиар, оны эхнээс 2.4 хувиар, өмнөх сарынхаас 1.0 хувиар өссөн байна.

Зураг II.3.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2017X сар, (өмнөх сар=100%)



Хүснэгт II.3.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2015-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017 XII 2016 XII	2017 XII 2016 XII	2017 XII 2017 XI
Ерөнхий индекс	100.0	102.4	102.4	101.0
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	105.7	105.7	102.4
Согтуу руулах ундаа, тамхи	3.2	104.0	104.0	100.0
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	97.4	97.4	100.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	102.5	102.5	100.2
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	100.2	100.2	100.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	103.8	103.8	100.5
Тээвэр	12.2	105.6	105.6	102.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.6	100.6	100.2
Боловсролын үйлчилгээ	4.7	100.1	100.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	108.2	108.2	101.6

II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2017 оны 4 улирлын байдлаар адууны шир 22.0 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 30.0 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 39.0 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны дэл 15.4 хувиар өссөн бол, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 50.0 хувиар, 2.3 метрээс дээш урттай шир 11.4 хувиар тус тус өссөн бол адууны шир 37.1 буурсан байна.

II.5 Малын дундаж үнэ

2017 оны 4 улирлын байдлаар тэмээ 885.0 мян.төг, адуу 610.0 мян.төг, үхэр 778.0 мян.төг, хонь 111.0 мян.төг, ямаа 79.0 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 0.7 хувиар өссөн бол адуу 5.8 хувь, үхэр 8.9 хувь, ямаа 8.1 хувь, хонь 5.9 хувиар тус тус буурсан байна.




II.6 Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны жилийн эцсийн байдлаар 3651.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6698.7 сая төгрөгийн борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 33.4 хувиар, борлуулалт 9 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх оноос үйлдвэрлэлт, борлуулалт буурсан шалтгаан нь аймгийн хэмжээнд үйлдвэрлэлт явуулалдаг Хангайн гурил ХХК, ИНТОСЭ ХХК, Орхон мандал ХХК гурилын үйлдвэрүүд үйлдвэрлэлт урьд оноос эрс бага 2017 онд гантай байснаас ургац алдаж үйлдвэрлэлт муу байгаас шалтгаалж байна.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт



II.7 Барилга

Барилга угсралт, их засварын ажил 2017 оны жилийн эцсийн байдлаар 28507.9 сая.төг-ний ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 19868.6 сая.төг буюу 329.9 хувиар өссөн байна. Барилга угсралт, их засварын ажил 2017 оны 4 дүгээр улиралд 10987.9 сая.төг болж өмнөх улирлаас 3119.0 сая.төг буюу 39.6 хувиар өсчээ.



II.8 Тээвэр

2017 оны эхний 4-улирлын байдлаар нийт 9475 тээврийн хэрэгсэл үзлэг оношилгоонд

хамрагдсан байна. Үүний 4489 нь суудлын автомашин, 3989 нь ачааны автомашин, 263 автобус, 483 мотоцикл, 97 нь чиргүүл байна. Эхний 4-улирлын байдлаар төсөвт нийт 225988 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг татвар төвлөрүүлсэн байна.




II.9 Холбоо

Шуудан холбооны салбарын орлого 2017 оны 4-р улиралд 522.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар буюу 54.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт орлогод хүн амаас орсон орлого 202.4 сая төгрөг байна. Үүрэн телефон хэрэглэгчдын тоо 36124 байна.

Зураг II.9.1

Холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд жилийн эцсийн байдлаар



II.11 Өмчийн газар

2017 оны 4-р улиралд 8 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, 13 тээврийн хэрэгсэл борлуулж, 46.5 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлсэн.

II.12 Худалдан авах ажиллагаа

2017 оны 4-р улирлын байдлаар орон нутгийн төсвөөс 7 төсөл арга хэмжээ буюу 1734.2 сая. төг, орон нутгийн хөгжлийн сангаас 5 төсөл арга хэмжээ буюу 455.0 сая.төгрөг, авто замын сангаас 3 төсөл арга хэмжээ буюу 382.7 сая.төгрөг, байгаль хамгаалах сангаас 12 төсөл арга хэмжээ буюу 1967.3 сая.төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 4 төсөл арга хэмжээ буюу 310.2 сая.төгрөг, нийт 31 төсөл арга хэмжээ буюу 4849.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж баталсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал орон нутгийн нийт бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын тоо хэмжээ 16.2 хувиар буурсан, төсөвт өртөг нь 23.2 хувиар өссөн байна.



II.14 Хөдөө аж ахуй

Мал төллөлт, төл бойжилт


Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1573.7 мянган хээлтэгч малын 1346.3 мянга буюу 85.6 хувь нь 2017 оны 4 улирлын байдлаар төллөсөн байна. Эм ямааны 87.5 хувь, эм хонины 86.9 хувь, ингэний 62.0 хувь, үнээний 78.8 хувь, гүүний 71.0 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал ижил хувьтай байна. Гарсан төлийн 96.1 буюу 1296.3 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр буурсан байна.

Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2017 оны 4 улирлын байдлаар 85.5 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 27.3 мян.толгой мал буюу 31.9 хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 9.0 мянга буюу 10.5 хувь, үхэр 10.0 мянга буюу 11.7 хувь, хонь 41.2 мянга буюу 48.1 хувь, ямаа 25.3 мянга буюу 29.6 хувь буюу оны эхний малын 1.8 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 77.7 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Орхон 18.0 хувь, Баян-агт сум 13.2 хувь, Бүрэгхангай сум 12.3 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Хорогдсон хээлтэгч 10.6 мянган толгой болж өмнөх оны мөн үеийнхээс 2.4 мянган толгой мал буюу 22.4 хувиар өссөн байна.


Зураг II.14.2

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 4 улирлын байдлаар, толгой



Зураг II.14.1

Том малын зүй бусын хорогдол



Мал эмнэлэгийн үйлчилгээ

2017 оны 4-р улирлын байдлаар 731 мян. толгой малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцин хийхээр төлөвлөгдснөөс 615.9 мян.толгой малд вакцин хийж, 84.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинныг 3235.8 мян.толгой малд хийсэн байна. 4-р улирлын байдлаар паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 121.0 мян.толгой бод мал, 1737.5 мян.толгой бог мал, 1.7 амьтан, нийт 1860.2 мян.толгой тэжээвэр амьтанд угаалга, туулгалт хийсэн байна. Мал амьтдын паразиттах өвчнөөр 813 голомтонд 29.3 мян.толгой мал өвчилж, 28.9 мян.толгой мал эдгэрсэн байна. Мал амьтдын халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 118 голомтонд гарч, 1.8 мянган толгой мал өвчилж, 317 толгой мал эдгэрч, 541 толгой мал үхэж, 992 толгой малыг устгасан байна. Лабораторийн оношлогоо, шинжилгээнд 71.0 мян.толгой мал, тэжээвэр амьтан, 1937.5 мян. кг мах, махан бүтээгдэхүүн, 27.9 мян.литр сүү, сүүн бүтээгдэхүүн, 109.7 мян.ширхэг арьс, шир, ноос ноолуур 1080.8 мян.кг, 34.5 мян.кг дайвар, 150 ширхэг өндөг үзлэгт хамрагдаж 100 хувь хэрэгцээнд тохирсон байна.

Тариалсан талбай өнгөрсөн оны мөн үеийхээс 16.2 хувиар буюу 6774.1 га-гаар өссөн. Үүнээс: үр тариа 5365.9 га буюу 14.3 хувь, тэжээлийн ургамал 22.4 га буюу 8.4 хувиар, техникийн ургамал 1765 га буюу 64.6 хувиар тус тус өссөн бол эмийн ургамал 152,5 га буюу 37.6 хувиар, хүнсний ногоо 99.89 га буюу 40.6 хувиар, төмс 126.81 га буюу 24.9 хувиар буурсан байна.

II.15 Газар өмчлөл

2017 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд газар өмчлөхөөр 920 иргэн хүсэлтээ гаргасаны 140 иргэн буюу 15.2 хувь нь одоо эзэмшиж, ашиглаж байгаа хашааныхаа газрыг өмчилж авах, 774 иргэн буюу 84.1 хувь нь шинээр газар өмчилж авах хүсэлт гаргасан байна. Хүсэлт гаргасан нийт иргэдийн хүсэлтийн 80.2 хувь шийдвэрлэж, 100.2 га газрыг өмчлүүлсэн байна. Иргэдийн өмчлөлд шилжсэн газрын 19.4 га буюу 19.3 хувь нь одоогийн эзэмшиж байсан газар нь, 80.7 га буюу 80.6 хувь нь шинээр олгогдсон газар байна.



II.15 Газар тариалан

2017 онд аймгийн хэмжээнд нийт 48559.2 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 42992.7 га, төмс 382.89 га, хүнсний ногоо 146.11 га, техникийн ургамал 4496 га, тэжээлийн ургамал 288 га, эмийн ургамал 253.5 га талбайд тус тус тариалтыг хийжээ.

Зураг II.14.2


Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалсан талбай 2017 оны байдлаар

I.I ХҮН АМ

Хүснэгт I.I.1 Хүн ам, эрэгтэй, эмэгтэй

Сум	Хүн ам			2017 2016	Эрэгтэй			2017 2016	Эмэгтэй			2017 2016
	2015	2016	2017		2015	2016	2017		2015	2016	2017	
Баян-Агт	3052	3119	12616	102.2	1550	1583	6125	102.1	1502	1536	6491	102.3
Баяннуур	1868	1818	3218	97.3	983	969	1632	98.6	885	849	1586	95.9
Бугат	2182	2241	1861	102.7	1132	1187	998	104.9	1050	1054	863	100.4
Булган	12234	12512	2277	102.3	6014	6104	1208	101.5	6220	6408	1069	103
Бүрэгхангай	2726	2832	2888	103.9	1388	1459	1482	105.1	1338	1373	1406	102.6
Гурванбулаг	3133	3176	3219	101.4	1617	1644	1660	101.7	1516	1532	1559	101.1
Дашинчилэн	2803	2941	3037	104.9	1431	1492	1540	104.3	1372	1449	1497	105.6
Могод	2685	2701	2729	100.6	1375	1383	1394	100.6	1310	1318	1335	100.6
Орхон	3482	3584	3595	102.9	1865	1911	1913	102.5	1617	1673	1682	103.5
Рашаант	3141	3165	3215	100.8	1583	1602	1618	101.2	1558	1563	1597	100.3
Сайхан	3575	3648	3662	102	1816	1854	1871	102.1	1759	1794	1791	102
Сэлэнгэ	3207	3306	3332	103.1	1666	1723	1733	103.4	1541	1583	1599	102.7
Тэшиг	3495	3504	3563	100.3	1786	1782	1820	99.8	1709	1722	1743	100.8
Хангал	4548	4611	4705	101.4	2282	2302	2343	100.9	2266	2309	2362	101.9
Хишиг-Өндөр	3154	3156	3158	100.1	1592	1595	1592	100.2	1562	1561	1566	99.9
Хутаг-өндөр	4729	4835	4952	102.2	2432	2487	2546	102.3	2297	2348	2406	102.2
Нийт хүн ам	60014	61149	62027	101.9	30512	31077	31475	101.9	29502	30072	30552	101.9

Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2017 он



I.2 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2016 XII		2017 XII		$\frac{2017 \text{ XII}}{2016 \text{ XII}}$	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	1456	709	1008	491	69.2	69.3
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	1066	523	703	356	65.9	68.1
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	542	261	1039	484	191.7	185.4
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	210	87	232	78	110.5	89.7
Уул уурхай олборлолт	28	3	92	9	328.6	300.0
Боловсруулах үйлдвэр	10	4	31	16	310.0	400.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт			12	1		
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1	1	8	7	800.0	700.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл			5	2		
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	2	1	20	14	1000.0	1400.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	10	8	65	25	650.0	312.5
Боловсрол	9	7	42	29	466.7	414.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7	7	78	56	1114.3	800.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа						
Бусад	265	143	454	247	171.3	172.7
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	1456	709	1008	491	69.2	33.7
15-24	159	81	131	66	82.4	81.5
25-34	472	227	345	178	73.1	78.4
35-44	400	211	233	122	58.3	57.8
45-54	318	155	219	104	68.9	67.1
55-59	73	25	54	13	74.0	52.0
60+	34	10	26	8	76.5	80.0
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	1456	709	1008	491	69.2	69.3
Магистр, доктор	2	2	4	3	200.0	150.0
Дипломын болон бакалаврын дээд	221	133	172	108	77.8	81.2
Тусгай мэргэжлийн дунд	52	33	38	15	73.1	45.5
Техникийн болон мэргэжлийн	72	28	44	18	61.1	64.3
Бүрэн дунд	758	371	598	290	78.9	78.2
Суурь	272	112	111	45	40.8	40.2
Бага	62	23	28	9	45.2	39.1
Боловсролгүй	17	7	13	3	76.5	42.9

I.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүснэгт I.3.1 Нийгмийн даатгалын зарлага, хамрагдсан хүн

	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2017 XII 2016 XII
	2016 XII	2017 XII	XII	XII	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10218	13921	4808980.0	4865153.5	101.2
Халамжийн тэтгэвэр	1394	1238	1776293.2	1657212.5	93.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	4335	4259	1586844.5	1663456.6	104.8
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	2534	2514	621583.3	619348.2	99.6
Ахмад настныг асарч буй иргэний	976	1030	534811.8	619969.7	115.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	509	440	259683.5	252922.1	97.4
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	287	248	156297.5	152388.9	97.5
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	29	27	14468.4	18827.7	130.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	4489	8424	1445842.3	1544484.4	106.8
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	1631	1718	296632.7	313372.1	105.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	395	368	87424.7	116589.5	133.4
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	2294	1678	664276.6	659696.2	99.3
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	50	12	15500.0	2000.0	0.0
Хүнс тэжээл хөтөлбөр		4,529	357195.5	428257.5	119.9
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ	119	119	24812.8	24569.1	99.0

I.3. НИЙГМИЙН ДААТГАЛ

Хүснэгт I.3.2 Нийгмийн даатгалын зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлтүүд	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2017 XII 2016 XII
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	10458.6	11998.5	12665.5	105.6
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	6788.9	7249.4	7460.9	102.9
Тэтгэмжийн даатгалын сан	768.9	825.8	974.8	118.0
Эрүүл мэндийн даатгалын сан	2204.4	3162	3461.9	109.5
ҮОМШӨ*-ний даатгалын сан	513.2	563.9	564	100.0
Ажилгүйдлийн даатгалын сан	183.2	197.4	203.9	103.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	29832.3	31482.7	35444.9	112.6
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	25577.9	27583.9	29805.9	108.1
Тэтгэмжийн даатгалын сан	1130.6	1049.9	1230.4	117.2
Эрүүл мэндийн даатгалын сан	2339.1	2259.9	3499.6	154.9
ҮОМШӨ*-ний даатгалын сан	541.8	240.8	540.5	224.5
Ажилгүйдлийн даатгалын сан	242.9	348.2	368.5	105.8

Хүснэгт I.3.3 Нийгмийн даатгалын зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлтүүд	Хүний тоо		Зарлага сая.төг		2017 I-XII
	2016 I-XII	2017 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2016 I-XII
Тэтгэврийн даатгалын сан	8484	8847	27583.9	29805.9	108.1
Тэтгэмжийн даатгалын сан	1995	2220	1049.9	1230.4	117.2
Эрүүл мэндийн даатгалын сан	64592	61604	2259.9	3499.6	154.9
ҮОМШӨ*-ний даатгалын сан	94	103	240.8	540.5	224.5
Ажилгүйдлийн даатгалын сан	303	0	348.2	368.5	105.8
Нийт дүн	75468	72774	31482.7	35444.9	112.6

